



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/30

Булган сум

### “Өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.10 дахь заалт, Засгийн газрын “Улсын нөөцөөс бараа, материал гаргаж, нөхөн бүрдүүлэх тухай” 449, 479 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нийт нутгаар өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан Улсын нөөцөөс олгож байгаа малын тэжээлийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Хуваарилагдсан малын тэжээлийг зориулалтын бусаар зарцуулах, дамлан худалдаалах зөрчлөөс урьдчилан сэргийлж, хяналт тавин ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Одхүү), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан), сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (хурандаа Ш.Баасандорж)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
01 дүгээр сарын 17-ны өдрийн А/ЗД дугаар  
захирамжийн хавсралт

СУМДАД ОЛГОХ МАЛЫН ТЭЖЭЭЛИЙН ХУВААРЬ

Д/д	Сумдын нэр	Тоо хэмжээ /тонн/
1	2	3
1	Баян-Агт	15
2	Баяннуур	25
3	Булган	10
4	Бугат	5
5	Бүрэгхангай	10
6	Хутаг-Өндөр	5
7	Гурванбулаг	25
8	Дашинчилэн	25
9	Тэшиг	5
10	Сайхан	10
11	Хангал	5
12	Хишиг-Өндөр	15
13	Хялганат	5
14	Орхон	10
15	Сэлэнгэ	5
16	Могод	20
17	Рашаант	20
18	АОК /нөөцөд/	60.6
<b>НИЙТ ДҮН</b>		<b>275,6</b>